



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 07 сарын 05 өдөр

Дугаар А/222

Мөрөн сум

Ажил зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.1, Эрүүл ахуйн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.8, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2022 оны 02 дугаар албан даалгаврыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аялал жуулчлалын улирал эхэлж байгаатай холбогдуулан сум суурин газрууд болон амралт жуулчны баазын ойролцоох гол мөрөн, нуур, уст цэгийн орчимд хог хаягдал ихээр хаягдаж, хогийн цэг үүсэх, мөн сумдын баяр наадмын үеэр сум хоорондын авто зам дагуу ил задгай хог хаягдал нэмэгдэж байгаа тул аймаг, сумын хэмжээнд бүх нийтийн цэвэрлэгээний ажлыг 2022 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн дотор зохион байгуулж, олон нийтэд чиглэсэн хог хаягдлын эсрэг нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

2. Хог хаягдлыг цэвэрлэх, гол мөрөн, нуур, уст цэгийг бохирдохоос сэргийлэх ажлын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.


3. Гол мөрөн, нуур, уст цэгийг бохирдохоос сэргийлэх, хог хаягдлыг цэвэрлэх ажил, зохион байгуулахад хяналт тавьж, хамтран ажиллахыг Хөвсгөл нуур-Эгийн голын сав газрын захиргааны дарга (И.Найманжин), Дэлгэрмөрөн, Шишхэд голын сав газрын захиргааны дарга (Ш.Түмэнбаяр), тайлан мэдээг аймгийн хэмжээнд нэгтгэн, дүгнэж 2022 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн дотор танилцуулахыг аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга (П.Мөнхжаргал) нарт тус тус даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (П.Ариунбат)-д даалгасугай.

ОРЛОГЧ

М.ХУЯГБААТАР

Аймгийн Засаг даргын 2022 оны 07 дугаар  
сарын 05-ны өдрийн 1/222 дугаар  
захирамжийн хавсралт



ГОЛ МӨРӨН, НУУР, УСТ ЦЭГИЙГ БОХИРДЛООС  
СЭРГИЙЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэгжүүлэх ажил	Хугацаа	Хариуцах, хамтран зохион байгуулах байгууллага, албан тушаалтан
1	Хатгал, Алаг-Эрдэнэ суманд ажиллаж, Эгийн голын доторх болон эрэг дагуух хог хаягдлын цэвэрлэгээний ажлыг зохион байгуулах, хяналт тавих	03/VII – 04/VII	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газрын төлөөлөл, Хөвсгөл нуур-Эгийн голын сав газар, аймгийн Онцгой байдлын газар, тухайн сумдын ЗДТГ
2	Аймгийн Засаг даргын захирамжийг хэрэгжүүлэх талаар бүх сумдын удирдлагуудтай цахим хурал хийх, чиглэл өгөх	04 /VII	Усны газрын мэргэжилтэн, Аймгийн Засаг дарга, ЗДТГ, БОАЖГ, Сав газруудын дарга нар
3	Усны хамгаалалтын бүсийн дэглэм мөрдүүлэх, тэмдэгжүүлэлтийн ажилтай танилцах, хогийн цэгийн асуудлаар Баянзүрх, Мөрөн сумдад ажиллах	05/VII-08/VII	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газрын төлөөлөл, Дэлгэрмөрөн, Шишхэд голын сав газрын захиргаа, сумын ЗДТГ
4	Усны хамгаалалтын бүсийн дэглэм мөрдүүлэх, хогийн цэгийн асуудлаар, үерийн эрсдэлтэй холбогдуулан Тариалан, Эрдэнэбулган сумдад ажиллах	06/VII-07/VII	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газрын төлөөлөл, Хөвсгөл нуур-Эгийн голын сав газар, БОАЖГазар
5	Зам дагуух болон гол уст цэгийн цэвэрлэгээний ажлыг бүх сумд зохион байгуулах, тайлан мэдээг нэгтгэх	08/VII	Аймаг, сумын ЗДТГ, БОАЖГ, сав газрын захиргаад
6	Баяр наадмын үеэр болон аялал жуулчлалын улиралд иргэд олон нийт, жуулчдад зориулсан нөлөөллийн ажлыг цахим болон хэвлэл мэдээллээр дамжуулан сурталчилах	05/VII-08/VII	Аймаг, Сумдын Засаг даргын Тамгын газар, БОАЖГ, Сав газрын захиргаад
7	Аймаг, сумын түвшинд хог хаягдлын талаар нөлөөллийн ажил, усан сан бүхий, аялал жуулчлалын зам, баяр наадам зохион байгуулах хэсгүүдэд нийтийн цэвэрлэгээ зохион байгуулах, хяналт тавих, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх	05/VII-08/VII	Аймгийн БОАЖГ, Сав газрын захиргаадын сумд хариуцсан мэргэжилтнүүд
8	Жил бүрийн 6,7,8 дугаар сард гол, мөрөн нуур уст цэгийн хог хаягдлыг цэвэрлэх ажил зохион байгуулж байх	VII, VIII сард	Сумдын Засаг даргын Тамгын газар
9	Гол мөрөн нуур уст цэгийг бохирдлоос сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын тайланг нэгтгэж тайлагнах	18/VII	БОАЖГ